



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/20.

Арвайхээр


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3.б, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2020-2024 онд хэрэгжүүлэх Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.2.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийж, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хуулийн хариуцлага тооцуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг холбогдох төлөвлөгөөг батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 11 дүгээр сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Т.Ариунболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100049

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 400 дүгээр захирамжийн хавсралт

**“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” АРГА ХЭМЖЭЭГ ОРОН НУТАГТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхай, нөхөн сэргээлт, байгаль орчны үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Гишүүдэд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Газар, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Цагдаагийн газрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч
 - Онги-Таац голын сав газрын захиргааны гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн
 - Сумдын Засаг дарга нар
 - Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байцаагч, байгаль хамгаалагч

-оОо-